



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/12

Чингис хот

Тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дугаар тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга	Л.Чулуун	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
Нарийн бичгийн дарга	Б.Хэрлэнчимэг	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Цаг уур, технологийн хэлтсийн дарга
Гишүүд	Б.Мөнхжаргал	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Оюунмандал	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Мэргэжилтэн
	Б.Ганганбайгаль	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн эрхлэгч

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг нутаг дэвсгэртээ 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд холбогдох журмын дагуу зохион байгуулж, дүнг аймгийн ажлын хэсэгт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг тогтоосон хугацаанд зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Л.Чулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010045